

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 06 сарын 04-ний өдөр

№ 21/25

Улаанбаатар хот

Хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.4, 80.7 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4, 9.6.20 дахь заалт, 9.10, 9.11, 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “Компани” гэх)-ийн Үйл ажиллагааны журмын 11 дүгээр зүйлийн 11.12 дах хэсэг, ТУЗ-ийн 2021 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн ээлжит бус хурлын эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Эх үүсвэр татан төвлөрүүлэх зорилгоор хавсралтад заасан хэмжээ, нөхцөлийн хүрээнд Итгэлцлийн үйлчилгээгээр хөрөнгө итгэмжлэн удирдах хэлцэл хийх эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д олгосугай.
2. Хөрөнгө итгэмжлэн удирдах хэлцэл хийхтэй холбогдуулан, “Райнос Инвестмент ҮЦК” ХХК-тай батлагдсан нөхцөлийн хүрээнд Зөвлөх үйчилгээний гэрээ байгуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тогтоолын дагуу авах гадаад вадютын эх үүсвэрийг зохистой түвшинд үр ашигтай удирдах, гадаад валютын эрсдэлээс хамгаалахад шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:





Ц.ОДМАА

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

 /С.БОРГИЛ/  /В.БАЯРСАЙХАН/

 /Ж.ЖАРГАЛСҮРЭН/  /С.ЭНХ-АМГАЛАН/

 /Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/  /О.БОЛДБААТАР/

 /Б.ӨЛЗИЙБАЯР/